



ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны
04 дүгээр сарын 30-ны өдрийн R-2025-22 дугаар тогтоолын Хавсралт 1

**ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТҮҮНИЙ
ЗАЛГАМЖ ХАЛААГ БЭЛДЭХ ЕРӨНХИЙ ЖУРАМ**

Хувилбар	4.0
Баталсан огноо	2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр
Нэмэлт өөрчлөлт оруулсан огноо	-
Баталсан	Төлөөлөн удирдах зөвлөл
Боловсруулсан	Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба
Холбогдох эрх зүйн баримт бичгүүд	▪ Компанийн тухай хууль ▪ Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын кодекс ▪ ХасБанкны засаглалын кодекс ▪ ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн Үйл ажиллагааны журам
Дагаж мөрдөх	Төлөөлөн удирдах зөвлөл

АГУУЛГА

1. НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
2. ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА
3. ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН
4. ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ.ТУЗ-ИЙН ГИШҮҮНД ТАВИГДАХ ШАЛГУУР
5. ТАВДУГААР ЗҮЙЛ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС НЭР ДЭВШҮҮЛСНЭЭС БУСАД ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ НЭР ДЭВШҮҮЛЭХ/ДАХИН НЭР ДЭВШҮҮЛЭХ
6. ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС НЭР ДЭВШҮҮЛСЭН ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ НЭР ДЭВШҮҮЛЭХ/ДАХИН НЭР ДЭВШҮҮЛЭХ
7. ДОЛООДУГААР ЗҮЙЛ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТОЛИЛУУЛАХ
8. НАЙМДУГААР ЗҮЙЛ. ЗАЛГАМЖ ХАЛААГ БЭЛДЭХ, ТҮР СУЛ ОРОН ТООГ НӨХӨХ
9. ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. БУСАД

Нэгдүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

- 1.1. ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, түүний залгамж халааг бэлдэх ерөнхий журам (“**Журам**”)-ын зорилго нь ХасБанкны алсын хараа, эрхэм зорилго, стратеги зорилтод нийцүүлэн ХасБанкны стратеги удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх, нийт хувьцаа эзэмшигч, оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, дэмжих зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөл (“**ТУЗ**”)-ийг түүний үндсэн үүргийг гүйцэтгэх зохих ур чадвар, давуу тал бүхий гишүүдээр бүрдүүлэхэд оршино.
- 1.2. Энэхүү журмаар ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр ажиллах боломжит нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах, үнэлэх, түүнчлэн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, дахин нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, томилох замаар ХасБанкны ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэх үйл ажиллагааны журам, аргачлалыг тогтооно.
- 1.3. Энэхүү журмыг ХасБанкны ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо (“**Хороо**”) хэрэгжүүлнэ.
- 1.4. Энэхүү журмыг ХасБанкны Дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон Хорооны Дүрмийн хамт мөрдөх бөгөөд энэхүү журмаар зохицуулаагүй аливаа харилцаанд холбогдох бусад хууль тогтоомж, бодлого журмыг баримтална.

Хоёрдугаар зүйл. Үүрэг, хариуцлага

- 2.1. ТУЗ нь ХасБанкны засаглал болон стратеги чиглэлийг тодорхойлогчийн хувьд дараах үүргийг хүлээнэ:
 - 2.1.1. ТУЗ-ийн гишүүнээр ажиллах боломжит нэр дэвшигчийг сонгон шалгаруулах, үнэлэх, түүнчлэн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, дахин нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, томилох талаарх бодлого, журмыг батлах;
 - 2.1.2. Чадвар, туршлага, олон талт байдлын тэнцвэрийг хадгалсан ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хангах;
 - 2.1.3. Энэхүү Журмын дагуу зохион байгуулах үйл ажиллагаанд хяналт тавьж, ХасБанкны ерөнхий стратеги, засаглалын бодлогод нийцүүлэх;
 - 2.1.4. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, эсхүл дахин нэр дэвшүүлэх талаарх Хорооны саналыг хэлэлцэх;
 - 2.1.5. Шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг түр томилох; мөн
 - 2.1.6. Холбогдох хууль тогтоомж болон компанийн засаглалын стандартыг дагаж мөрдүүлэх.
- 2.2. Хороо нь дараах үүрэг хүлээнэ:
 - 2.2.1. ТУЗ-ийн гишүүнээр ажиллах боломжит нэр дэвшигчийг сонгон шалгаруулах, үнэлэх, түүнчлэн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, дахин нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, томилох талаарх бодлого, журмын хэрэгжилтэд тухай бүр хяналт тавьж, ТУЗ-өөр батлуулахаар боловсруулах;
 - 2.2.2. Тавигдах шалгуурт үндэслэн ТУЗ-ийн гишүүнээр ажиллахад тохирох нэр дэвшигчийг тодорхойлох;

- 2.2.3. Боломжит нэр дэвшигчийн бичиг баримттай урьдчилан танилцаж, ярилцлага хийх;
- 2.2.4. Тавдугаар зүйлд заасны дагуу ТУЗ-өөр хэлэлцүүлсний үндсэн дээр ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, дахин нэр дэвшүүлэх асуудлаар Хувьцаа эзэмшигчдэд санал хүргүүлэх;
- 2.2.5. ТУЗ-ийн гишүүнээр түр томилох асуудлаар ТУЗ-д санал хүргүүлэх;
- 2.2.6. ТУЗ-ийн гишүүдэд зориулсан сургалтын зохион байгуулалт, явцад хяналт тавих;
- 2.2.7. ТУЗ-ийн гишүүдийн залгамж халааг бэлтгэх үйл ажиллагааг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх; мөн
- 2.2.8. Энэ Журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай аливаа бусад үүрэг.

Гуравдугаар зүйл. ТУЗ-ийн бүрэлдэхүүн

- 3.1. ХасБанкны ТУЗ нь хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудаас гадна ХасБанкны эрх ашгийг бүхэлд нь хамгаалж чадахуйц, аливаа зүйлийг өргөн хүрээнд авч үздэг, ур чадвартай, үр дүнтэй шийдвэр гаргах боломжийг олгосон бүрэлдэхүүнтэй байна.
- 3.2. Хороо нь компанийн өнөөгийн болон цаашдын хэрэгцээ шаардлагыг тогтоож, дараах шаардлагад нийцсэн ТУЗ-ийн бүтцийг бий болгохын тулд ТУЗ-ийн бүрэлдэхүүнд тогтмол хяналт тавина:
 - 3.2.1. Бизнесийн үйл ажиллагаанд ач холбогдол бүхий, тухайн салбарын асуудлыг ойлгох тодорхой туршлага, ур чадвартай байх;
 - 3.2.2. ТУЗ-ийн ердийн гишүүдийн бүрэлдэхүүнд гүйцэтгэх удирдлагаас зохистой хэмжээнд оруулах;
 - 3.2.3. Бие даан санаачилга гарган ажиллах болон шударга шийдвэр гаргах чадвартай байх;
 - 3.2.4. ХасБанкны үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлдэг байх; мөн
 - 3.2.5. Удирдлагын гүйцэтгэлд хяналт тавих чадвартай байх, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэлтэй холбоотойгоор шаардлага тавих.

Дөрөвдүгээр зүйл. ТУЗ-ийн гишүүнд тавигдах шалгуур

- 4.1. Хороо нь дараах шалгуурыг хангасан, боломжит шинэ нэр дэвшигчийг ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлнэ:
 - 4.1.1. Нэр дэвшигч нь ХасБанкны үйл ажиллагааны зорилго, салбарт хамаарах өргөн хүрээний банкны болон бизнесийн бусад туршлага, чадвартай байх;
 - 4.1.2. Нэр дэвшигчийн биеэ авч явах байдал болон ёс зүйн зан төлөв өндөр түвшинд байх;

- 4.1.3. Нэр дэвшигч нь ТУЗ-ийн гишүүний хүлээсэн үүргийг биелүүлэхэд шаардагдах цаг хугацаа, хүч, анхаарлаа зориулах боломжтой, хүсэл эрмэлзэлтэй байх;
- 4.1.4. Нэр дэвшигч нь ХасБанкны үнэт зүйлс, эрхэм зорилго болон ёс зүйн дүрэмд нийцэж ажиллах, бүх хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад тууштай байхаа илэрхийлсэн байх; мөн
- 4.1.5. Нэр дэвшигч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан Улс төрд нөлөө бүхий этгээд биш байх.
- 4.2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нь ТУЗ-ийн гишүүнээр сонгогдох/дахин сонгогдох, эсхүл томилогдохоос өмнө болон түүнээс хойш, бүрэн эрхийнхээ бүхий л хугацаанд Банкны тухай хуульд заасан ТУЗ-ийн гишүүнд тавигдах дараах шаардлагыг хангах ёстой:
- 4.2.1. Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй;
- 4.2.2. Эдийн засаг, авлига, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;
- 4.2.3. Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь ХасБанкийг удирдахад харшлахгүй байх;
- 4.2.4. Хэрэв нэр дэвшигч нь санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажилладаг бол энэ нь ХасБанкны шийдвэр гаргах ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхүйц сонирхлын зөрчил үүсгэхээргүй байх ёстой. Энэ зорилгын хүрээнд дараах нөхцөлийн аль нэг бүрдсэн тохиолдолд нэр дэвшигчийг сонирхлын зөрчилтэй гэж тооцно:
- i. Сүүлийн 12 сарын дотор Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй ХасБанкнаас бусад банкны эрх бүхий албан тушаалтан, ажилтан, эсхүл гаргасан хувьцааны 1 ба түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч байсан, эсхүл байгаа бол; эсхүл
 - ii. Сүүлийн 12 сарын дотор ХасБанкны нийт хөрөнгийн 2 хувиас дээш дүнтэй тэнцэх хэмжээний нийт хөрөнгө бүхий Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй Санхүүгийн нэгдэл (ХасБанкны толгой компани болох Тэнгэр Санхүүгийн Нэгдлээс бусад), ББСБ, эсхүл Зээлийн агрегаторын эрх бүхий албан тушаалтан, ажилтан, эсхүл нөлөө бүхий хувьцаа эзэмшигч (гаргасан хувьцааны 5 ба түүнээс дээш хувийг эзэмших хувьцаа эзэмшигч) байсан, эсхүл байгаа бол.
- 4.2.5. Зөрчлийн улмаас банк ба банк бус санхүүгийн байгууллагын зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан бол зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш гурван жил өнгөрсөн байх;
- 4.2.6. Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээсэн бол үүнээс хойш гурван жил өнгөрсөн байх;

- 4.2.7. Дээд боловсролтой, банк, санхүү, эдийн засаг, хууль эрх зүй, мэдээллийн технологи, компанийн засаглалын чиглэлээр мэргэшсэн, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүнээс таваас доошгүй жил банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаал хашсан туршлагатай байх; мөн
- 4.2.8. Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх.
- 4.3. ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч нь ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох/дахин сонгогдох, эсхүл томилогдохоос өмнө болон түүнээс хойш, бүрэн эрхийнхээ бүхий л хугацаанд, энэхүү Журмын 4.2 дахь хэсэгт дурдсан шаардлагаас гадна Банкны тухай хууль болон Компанийн тухай хуульд заасан дараах нэмэлт шаардлагыг хангах ёстой:
- 4.3.1. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран ХасБанк, түүний нэгдлийн оролцогчийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй;
- 4.3.2. ХасБанк, түүний нэгдлийн оролцогчид сүүлийн таван жилийн хугацаанд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээс бусад эрх бүхий албан тушаалтан, сүүлийн гурван жилийн хугацаанд бусад ажилтнаар тус тус ажиллаж байгаагүй;
- 4.3.3. ХасБанкны үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтээс хамаарч урамшуулал авч байгаагүй, авдаггүй байх;
- 4.3.4. Төрийн албаны тухай хуульд заасан Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;
- 4.3.5. ХасБанкны үйл ажиллагаа, гүйцэтгэх удирдлагад хяналт тавихад саад учруулах аливаа нөхцөл байдал үүсээгүй байх;
- 4.3.6. Эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон байх;
- 4.3.7. ХасБанк, түүний нэгдлийн оролцогчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээд биш байх;
- 4.3.8. Нэгдмэл сонирхолтой этгээд нь ХасБанкны болон ХасБанк оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй; мөн
- 4.3.9. ХасБанктай бизнесийн аливаа холбоогүй.
- 4.4. Нэр дэвшигчдийг сонгон шалгаруулахдаа дараах нөхцөлийг давуу тал гэж үзнэ:
- 4.4.1. Монгол улсад оршин суудаг байх;
- 4.4.2. Хүйсийн тэгш байдлыг хангах зорилтот түвшинд хүрээгүй тохиолдолд дутуу төлөөлөлтэй хүйсийн нэр дэвшигч байх;
- 4.4.3. ТУЗ-ийн бусад гишүүнд байхгүй ур чадвартай байх;

- 4.4.4. Олон улсын болон Монгол улсын бизнесийн орчинд танигдсан, нэр хүндтэй, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн, ихээхэн туршлагатай, мэргэжлийн үйл ажиллагааны хувьд амжилт гаргасан байх; мөн
- 4.4.5. Урт хугацаанд манлайлан ажиллах, ХасБанкны залгамж халааг бэлтгэх төлөвлөгөөнд нийцүүлэн засаглалын залгамж чанарт хувь нэмрээ оруулах чадвартай байх.
- 4.5. Одоогийн ТУЗ-ийн гишүүдийн ур чадвар, туршлага, мэргэшлийн үнэлгээнд үндэслэн Хороо нь сонгон шалгаруулах шалгуурыг илүү боловсронгуй, тодорхой болгохоор ТУЗ-д санал болгох, батлуулах, шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах нэмэлт шалгуурыг тодорхойлж болно.

Тавдугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлснээс бусад ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх/дахин нэр дэвшүүлэх

- 5.1. Хороо нь хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлснээс бусад ТУЗ-ийн гишүүнээр сонгогдох шаардлага хангасан нэр дэвшигчийг нээлттэй зарын болон/эсхүл бусад аргаар тодорхойлж, нягтлан шалгаж, санал болгоно. Энэхүү үйл ажиллагааг ТУЗ-ийн гишүүдийг сонгох Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болохоос өмнөх жилийн гуравдугаар улиралд багтаан эхлүүлнэ. Хороо нь нэр дэвшигчдийг тодорхойлох явцдаа хөндлөнгийн зөвлөхүүдээс санал авч болно.
- 5.2. Нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт гарсны дараа Хороо анхан шатны сонгон шалгаруулалтыг эхлүүлнэ. Энэ шатанд ТУЗ-ийн бүх гишүүдийг оролцохыг урьж, хамруулна. Компанийн тухай хууль болон Банкны тухай хуульд заасан шалгуурыг илтэд хангаагүй нэр дэвшигчийг энэ шатанд жагсаалтаас хасна. Анхан шатны шалгаруулалтыг Хорооны хурлын хэлбэрээр зохион байгуулж бүртгэнэ. Энэ үе шатанд Хороо нэр дэвшигчийн шаардлага хангасан эсэхийг нотлох баримт бичгүүдийг цуглуулах ажлыг эхлүүлнэ.
- 5.3. Хороо нь энэ журмаар тодорхойлсон шалгуурыг ашиглан хувьцаа эзэмшигчдийн нэр дэвшүүлснээс бусад бүх нэр дэвшигчдийг үнэлнэ. Үнэлэх ажиллагаанд Хорооны гишүүд болон ТУЗ-ийн бусад гишүүд биечлэн ярилцлага хийх, анкетыг нарийвчлан судлах, тодорхойлолт өгсөн этгээд, эсхүл хөндлөнгийн үнэлгээчидтэй ярилцлага хийх зэрэг хамаарч болно.
- 5.4. Монголбанкнаас зөвшөөрөл авах болон Хувьцаа эзэмшигчдийн хуралд эцсийн байдлаар санал хүргүүлэхийн өмнө Хороо нь нэр дэвшигчдийн жагсаалтыг ТУЗ-тэй зөвшилцөнө. Энэ зорилгоор Хороо нь өөрийн хийсэн үнэлгээ болон зөвлөмжийг тусгасан тайланг ТУЗ-д хүргүүлнэ. Хороо нь үнэлгээний үр дүнд үндэслэн санал болгож буй нэр дэвшигчээ тус тайланд тодорхойлох ба тайланд дараах зүйлс багтсан байна:
- 5.4.1. Нэр дэвшигч тодруулсан үйл явц, зарцуулсан хугацаа, нэр дэвшигч бүрийн ур чадвар болон энэхүү ур чадвар нь ХасБанкны стратегийн хэрэгцээнд хэрхэн нийцэж буй талаарх дүгнэлт бүхий, нэр дэвшигчдийг сонгох, сонгохгүй байх үндэслэлийг агуулсан тайлан;
- 5.4.2. Тодорсон нэр дэвшигч бүрийн анкетын нарийвчилсан судалгаа, бусад этгээдээс өгсөн тодорхойлолт, эсхүл судалгааны явцад илэрсэн болзошгүй эрсдэл, асуудлуудын тайлан;

- 5.4.3. Хэрэв бий бол, боломжит нэр дэвшигчдийн талаар томоохон оролцогч талуудаас ирүүлсэн санал, хүсэлт;
- 5.4.4. Нэр дэвшигч нь сонгогдсон тохиолдолд ТУЗ-д ажиллах хүсэлтээ илэрхийлсэн эсэх;
- 5.4.5. Үйл ажиллагааны явцад илэрсэн сонирхлын зөрчлийн асуудал болон тухайн зөрчлийг бууруулах зорилгоор авсан арга хэмжээ; мөн
- 5.4.6. Хорооны шийдвэрт нөлөөлсөн бусад хүчин зүйлс.
- 5.5. Банкны ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх (гуравны хоёр) зөвшөөрсний үндсэнд, Хороо нь нэр дэвшигчдийн нэрсийн бүрэн жагсаалтыг холбогдох хууль тогтоомж, журамд нийцүүлэн зохицуулагч байгууллагаас авах зөвшөөрлийн хүсэлтийн хамт нэн даруй Монголбанкинд хүргүүлнэ.
- 5.6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүнээр сонгосон, эсхүл ТУЗ түр гишүүнээр томилсон тохиолдолд аливаа нууц мэдээллийг хүлээн авах, эсхүл ТУЗ-ийн болон/эсхүл хорооны хуралд оролцохоос өмнө ТУЗ болон хорооны үүрэг хариуцлагыг биелүүлэхэд хангалттай цаг хугацаа зориулах амлалт гаргаж, тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж буй ТУЗ-ийн гишүүний үйлчилгээний гэрээнд гарын үсэг зурахаа батлан илэрхийлээгүй аливаа нэр дэвшигчийг Хороо санал болгохгүй.
- 5.7. Монголбанкны зөвшөөрөл Хувьцаа эзэмшигчдийн хурлаар нэр дэвшигчдийг сонгосны дараа ирсэн тохиолдолд, тухайн нэр дэвшигчийг зөвхөн Монголбанкны зөвшөөрөл авсны дараа ТУЗ-ийн гишүүн болсонд тооцно. Харин Монголбанк зөвшөөрөл олгоогүй тохиолдолд тухайн гишүүний орон тоог сул болсонд тооцож, Долоодугаар зүйлд заасны дагуу нөхөн томилно.

Зургаадугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлсэн ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх/дахин нэр дэвшүүлэх

- 6.1. Нийт гаргасан хувьцааны тав буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг санал болгож болно. Энэхүү саналаа Компанийн тухай хуулийн хуульд заасан журмын дагуу, тус хуульд заасан хугацаа (санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор)-нд багтаан дараах мэдээллийн хамт Банкинд ирүүлнэ:
- 6.1.1. Нэр дэвшигчийн нэр (эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр), хэрэв ХасБанкны хувьцаа эзэмшигч бол хувьцааны тоо;
- 6.1.2. Нэр дэвшүүлж буй хувьцаа эзэмшигчийн нэр (эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр), ХасБанкинд эзэмшиж буй хувьцааны тоо;
- 6.1.3. хэрэв хамаарах бол, нэр дэвшүүлэх/дахин нэр дэвшүүлж буй шалтгаан; мөн
- 6.1.4. Тухай бүр нэмэлт, өөрчлөлт орсон Компанийн тухай хуульд заасан бусад шаардлагатай мэдээлэл.
- 6.2. Нэр дэвшүүлэх саналыг Монголбанкинд хүргүүлэх бүрдэл хангагдсан баримт бичгүүдийн хамтаар ирүүлнэ.
- 6.3. Хэрэв Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг болон 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан шаардлагыг илтэд зөрчөөгүй бол, Хороо нь хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлсэн

этгээдүүдийг бүртгэж, тухайн нэр дэвшигчдийг томилох зөвшөөрөл авахаар Монголбанкинд шууд хүргүүлэх ба хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар ТУЗ-д уламжилна. Хувьцаа эзэмшигчээс нэр дэвшүүлсэн нэр дэвшигчийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх эцсийн нэр дэвшигчдийн жагсаалтад шууд оруулна.

- 6.4. Дутуу болон шаардлагатай нэмэлт материалуудыг Монголбанкинд нэн даруй хүргүүлнэ. Нэр дэвшигч эсвэл нэр дэвшүүлж буй хувьцаа эзэмшигч нь шаардлагатай баримт бичгийг Монголбанкнаас зөвшөөрөл авах хугацаанд нь хүргүүлээгүй тохиолдолд Банк хариуцлага хүлээхгүй.
- 6.5. Хувьцаа эзэмшигчээс нэр дэвшүүлсэн этгээд нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон, эсвэл ТУЗ-д түр орлох гишүүнээр томилогдсон тохиолдолд, аливаа нууц мэдээллийг хүлээн авах, эсхүл ТУЗ-ийн болон/эсхүл хорооны хуралд оролцохоос өмнө ТУЗ болон хорооны үүрэг хариуцлагыг биелүүлэхэд хангалттай цаг хугацаа зориулах амлалт гаргаж, тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж буй ТУЗ-ийн гишүүний үйлчилгээний гэрээнд гарын үсэг зурахаа батлан илэрхийлнэ.
- 6.6. Монголбанкны зөвшөөрөл Хувьцаа эзэмшигчдийн хурлаар нэр дэвшигчдийг сонгосны дараа ирсэн тохиолдолд, тухайн нэр дэвшигчийг зөвхөн Монголбанкны зөвшөөрөл авсны дараа ТУЗ-ийн гишүүн болсонд тооцно. Харин Монголбанк зөвшөөрөл олгоогүй тохиолдолд тухайн гишүүний орон тоог сул болсонд тооцож, Наймдугаар зүйлд заасны дагуу нөхөн томилно.

Долдугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдэд толилуулах

- 7.1. Хорооноос болон хувьцаа эзэмшигчээс нэр дэвшүүлсэн нэр дэвшигчийг ТУЗ-ийн гишүүнээр сонгохоор хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна.
- 7.2. ТУЗ-ийн гишүүнээр дахин нэр дэвшүүлсэн нэр дэвшигчийг түүний нийт ажилласан жил, хийж гүйцэтгэсэн ажил, ололт амжилтын талаарх дэлгэрэнгүй тайлан болон өмнөх хугацааны гүйцэтгэлийн үнэлгээний хамт хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна.
- 7.3. Хараат бус гишүүнд нэр дэвшүүлсэн нэр дэвшигчийн хараат бус байдлыг тогтоох үйл явц, мөн тухайн нэр дэвшигч өөр байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэхийг хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр тодорхой тайлбарлана.

Наймдугаар зүйл. Залгамж халааг бэлдэх, түр сул орон тоог нөхөх

- 8.1. Хороо нь ТУЗ-ийн дарга, Хорооны дарга болон ТУЗ-ийн бусад түлхүүр удирдах албан тушаалтны залгамж халааг бэлдэх төлөвлөгөөг хянаж, санал болгох үүрэгтэй. Эдгээр санал нь Банкны урт хугацааны стратеги чиглэл, удирдлагын хэрэгцээ болон засаглалын залгамж чанар зэргийг харгалзсан байна.
- 8.2. ТУЗ-д гэнэтийн сул орон тоо үүссэн тохиолдолд, хорооноос санал болгосны үндсэнд ТУЗ нь холбогдох хууль тогтоомжийн дагуу ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг түр томилж болно. Түр орлон гүйцэтгэх гишүүн нь тухайн сул орон тоонд хамаарах хууль, журамд заасан бүх шаардлагыг хангасан байна.
- 8.3. Өмнө нь хувьцаа эзэмшигчээс нэр дэвшүүлсэн ТУЗ-ийн гишүүний орон тоо сул болсон тохиолдолд тухайн хувьцаа эзэмшигч уг орон тоог нөхөхөөр шинэ этгээдийг

нэр дэвшүүлж болно. ТУЗ нь уг нэр дэвшсэн этгээдийг холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасны дагуу хэлэлцэн хянана.

Есдүгээр зүйл. Бусад

- 9.1. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх/дахин нэр дэвшүүлэхтэй холбоотой бүхий л хэлэлцүүлэг, үнэлгээ нууц байна. Хорооны гишүүд, ТУЗ-ийн гишүүд болон тус ажиллагаанд оролцсон бусад оролцогч нар мэдээллийн нууцыг хадгална.
- 9.2. Нэр дэвшигчтэй холбоотой сонирхлын зөрчил үүсэж болзошгүй аливаа ТУЗ-ийн гишүүн, ажилтан, хорооны гишүүн тухайн сонирхлоо мэдэгдэж, нэр дэвшүүлэх болон санал хураах ажиллагаанд оролцохоос татгалзах үүрэгтэй.
- 9.3. Хорооны зөвлөмж болон шийдвэрийг тухайн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонх (гуравны хоёр)-ын саналаар батална.

-o0o-